

МОНГОЛЫН ТЭТГЭВРИЙН ТОГТОЛЦООНД ҮНДЭСНИЙ СУУРЬ ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫГ НЭВТРҮҮЛЭХ БОЛОМЖ

Ж.Энхбаяр Доктор (Ph.D), дэд проф
Н.Тунгалаг Доктор (Ph.D), проф.
Л.Оюунцэцэг

Түлхүүр үг:

Тэтгэврийн тогтолцоо, тэтгэврийн даатгал, олон давхаргат тэтгэврийн тогтолцоо, тэтгэврийн шинэ давхарга, суурь тэтгэврийн даатгал, амьжиргааны баталгаажих түвшин, тэтгэврийн даатгалын актуар тооцоо.

Хураангуй:

Өнөөдөр тэтгэврийн даатгалын тогтолцоо санхүүгийн хүндрэлд орсон, тэтгэврийн хэмжээ нь өндөр настны амьжиргааны баталгаа болж чадахгүй байгаа ч төр засгаас дорвитой шинэчлэл хийж чадахгүй байна. Үүнийг шийдвэрлэж болох гарц бол олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх бөгөөд бидний тооцоогоор иргэд одооноос хамгийн багадаа 2-3 төрлийн тэтгэврийн даатгалд хамрагдах шаардлагатай. Бид үндэсний суурь тэтгэврийн даатгал, нэрийн дансны тэтгэврийн даатгал, нэмэлт тэтгэврийн даатгал гэсэн гурван давхаргыг санал болгож байгаа бөгөөд үндэсний суурь тэтгэврийн даатгалыг монголын тэтгэврийн тогтолцоонд нэвтрүүлэхтэй холбоотой тооцоо судалгааг хийсэн болно. Үндэсний суурь тэтгэврийн даатгалд иргэд хамгийн багадаа 25 жилийн хугацаанд шимтгэлээрээ хуримтлал бий болгож 15-16 жил тэтгэвэр авахдаа тэтгэвэрт гарах үеийнхээ амьжиргааны баталгаажих түвшинтэй тэнцүү хэмжээний тэтгэврийг суурь болгон авахаар төсөөлсөн болно. Үүний тулд урт хугацааны даатгалын зарчмаар тодорхой хэмжээний сан бүрдүүлсэн байх шаардлагатай бөгөөд тэр нь дараах томъёогоор илэрхийлэгдэнэ.

$$B_t = \frac{X[(1+r)^{mt}-1]}{r(1+r)^{mt}} = X \frac{[q^{mt}-1]}{r(q^{mt}-q^{-1})} \quad (1)$$

(1)-ээс даатгуулагчийн сар тутам төлөх хураамжийг дараах байдлаар тооцно.

$$a = B_t * \frac{r(1+r)^{mt}}{(1+r)^{mt}-1} \quad (2)$$

Үндэсний суурь тэтгэврийн даатгалыг нэвтрүүлэх судалгаа, тооцоо

Тэтгэврийн тогтолцоо нь түүхэн хөгжлийнхөө явцад өндөр насны улмаас хөдөлмөрийн чадвар алдагсдын нийгмийн асуудлыг тодорхой хэмжээнд шийдвэрлэж ирсэн. Өнөөдөр тэтгэврийн даатгалын тогтолцооны өмнө тулгамдаж буй шийдвэрлэвэл зохих асуудлуудыг бид дараах чиглэлүүдээр тодорхойлов. Үүнд:

- Тэтгэврийн даатгалын сангийн алдагдал тасралтгүй өсөх хандлагатай байгаа нь тулгамдсан асуудал мөн.

Өнөөгийн тэтгэврийн тогтолцоо нь нэг давхаргатай, эв санааны нэгдлийн зарчмаар буюу шимтгэлийн орлогоороо тэтгэврийн зардлаа санхүүжүүлдэг хуваарилалтын тогтолцоо бөгөөд хэрвээ тэтгэврийн даатгалын тогтолцоонд өөрчлөлт, шинэчлэлт хийхгүй бол 2015 онд ДНБ-ний 2,5 хувьтай тэнцээд байгаа тэтгэврийн сангийн алдагдал 2020 онд 4.5 хувь, 2030 онд 7 хувь, цаашдаа 12-14 хувьд хүрэх¹ төлөвтэй байна.

- Хүн амын насны бүтэц өөрчлөгдөж, хүн ам зүйн ачаалал нэмэгдэх


1 <http://economy.news.mn/content/187560.shtml>

Монголын тэтгэврийн тогтолцоонд үндэсний суурь тэтгэврийн даатгалыг нэвтрүүлэх боломж

хандлагатай байгаа нь шийдлээ хүлээсэн асуудлын нэг мөн.

Монгол Улсад хүн амын насжилт эрчимтэй явагдаж байгаа нь ажиллах хүч, эдийн засаг, өрхийн амьжиргаанд ихээхэн үр дагавар үзүүлэх хандлагатай байна. 1970 онд нөхөн үржихүйн насны нэг эмэгтэйд 7,5 төрөлт ноогдож байсан бол 2014 онд 2,5 дахин буурсан², дундаж наслалт 1950 онд 43,5 байсан бол 2014 онд 69,57 болж өссөн³ байна.

Дүрслэл 1. Хүн амын нас хүйсийн суварга




Эх сурвалж: Л.Мөнхзул (НДЕГ) <http://www.info.mn/news/51006.htm> 2014-06-05

PROST загвараар тооцоолсон хүн амын нас хүйсийн суваргаас харахад 2085 он хүртэл дундаж наслалт өсч монгол улс ямар ч эргэлзээгүйгээр хүн амын хөгширсөн бүтэцтэй⁴ орны тоонд багтахгаар байгааг судлаачид тогтоожээ.

Дундаж наслалтын энэхүү өсөлт нь өнөөдрийн тэтгэврийн насны иргэдийн тоо, тэдгээрийн тэтгэвэр авах хугацаа нь нэмэгдсэн гэдгийг харуулахаас гадна хүн ам зүйн ачаалал өсөх нөхцөлийг бүрдүүлсэн. Дүрслэл 3-аас 2085 онд нэг даатгуулагчид нэг өндөр настан ноогдохоор харагдаж байна.

Дүрслэл 2. 10 даатгуулагчид ногдох тэтгэвэр авагчийн тоо



2 <http://1212.mn/statHtml/statHtml.do>

3 Мөн тэнд

4 Улс орны хүн амын 10 хувиас илүү нь өндөр насных бол хүн амын хөгшин бүтэцтэй орон гэж үздэг.

Эх сурвалж: Л.Мөнхзүл (НДЕГ) <http://www.info.mn/news/51006.htm> 2014-06-05

- Тэтгэврийн даатгалын хамрах хүрээ хангалтгүй байна.

Хөдөлмөрийн болон бусад гэрээгээр ажиллаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос ажилтан, төрийн албан хаагчид тэтгэврийн даатгалд заавал шимтгэл төлж даатгуулдаг. Харин малчин, хувиараа болон албан бус хөдөлмөр эрхлэгчидэд зориулсан албан журмын тэтгэврийн даатгалын хөтөлбөргүйгээс иргэд даатгалд бүрэн хамрагдахгүй байгаа нь эдгээр иргэд өндөр насны тэтгэвэрт гарах үед нэг бол хамгийн бага тэтгэвэр авна, эсвэл огт тэтгэвэргүй (орлогогүй) байхад хүргэнэ.

Хүснэгт 1. Иргэдийн даатгалд хамрагдалт (хувиар)

Он	2000	2005	2010	2013	2014
Даатгуулаагүй	55	64	44	33	27
Сайн дураар даатгуулсан	2	3	6	7	9
Даатгуулсан	43	33	50	60	64

Эх сурвалж: Нийгмийн даатгалын статистикийн эмхэтгэл 2014

Тэрчлэн тэтгэврийн нэрийн дансны хуримтлалын өнөөгийн тогтолцоогоор тэтгэвэрт гарах иргэдийн тэтгэврийн хэмжээ нь өмнөх тогтолцооны зарчмаар тэтгэвэр тогтоолгож буй иргэдийн тэтгэврээс ихээхэн ялгаатай тогтох хандлага байна. Өмнөх тогтолцоогоор тэтгэвэр тогтоолгож байгаа иргэд доод тэтгэвэр 207,0 мянган төгрөг, дундажаар 283,0 мянган төгрөгийн тэтгэвэр авч байна. Тэтгэврийн нэрийн дансны тогтолцооны хэрэгжилтийн байдалд үнэлгээ хийсэн судлаачид нэрийн дансны тогтолцоогоор тэтгэвэрт гарах даатгуулагчийн тэтгэврийн хэмжээг таван хувилбараар тооцоолж үр дүнг гаргасан байна⁵.

Хувилбар	Тэтгэврийн хэмжээ
Хувилбар 1: Өнөөгийн хүү, хуулийн дагуу тэтгэвэрт гартал үлдэгдэлд хүү тооцох	78 727.94
Хувилбар 2: Өнөөгийн хуулийн дагуу, гэхдээ үлдэгдэл 0 болтол хүү тооцох	88 264.84
Хувилбар 3: Үлдэгдэлд зах зээлийн жишгээр тэтгэвэрт гартал хүү тооцох	204 681.53
Хувилбар 4: Үлдэгдэлд зах зээлийн жишгээр 0 болтол хүү тооцох	515 243.16
Хувилбар 5: Тэтгэвэрт гартал нь зах зээлийн жишгээр, тэтгэвэрт гарснаас хойш 1,15% хүү тооцох	229 476.13

Дээрх тооцооллын үр дүнгээс харахад өнөөгийн тогтолцоогоор тэтгэвэр тогтоолгох иргэдийн шимтгэлийн орлогыг багадаа зах зээлийн хүүгээр өсгөхгүй бол амьжиргааны баталгаа болохгүй нь харагдаж байна.

- Өндөр настны өнөөдрийн тэтгэвэр орлого тэдний амьжиргааны баталгаажих түвшинг хангаж чадахгүй байна.

Өнөөдрийн тэтгэврийн насны иргэдийн орлогын хэмжээ амьдралын наад захын хэрэгцээг хангаж чадахгүй (амьжиргааны баталгаажих доод түвшин 185,4 мян. төг), арилжааны банкуудад тэтгэвэр барьцаалсан зээлийн хэмжээ жил ирэх тусам нэмэгдэж байгаа бөгөөд тэтгэврийн иргэдийн 80 гаруй хувь нь тэтгэврийн зээлтэй (3-12 сарын хугацаатай)⁶, өрхийн сарын нийт зардал 1036,9 төгрөг, үүнээс мөнгөн зардал нь 993,9 төгрөг⁷, дундаж тэтгэвэр 283,0⁸ төгрөг байгаа зэрэг нь энэхүү дүгнэлтийг хийхэд хүргэж байна.


Эдгээр тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхийн тулд тэтгэврийн даатгалын олон давхаргат 5 Р.Энхбат нар "Тэтгэврийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, даатгалын тогтолцоог шинэчлэх" судалгааны ажил 2006 он, 81 тал

6 <http://www.unen.mn/wap/content/44935.shtml> 2015.01.13

7 Статистикийн эмхэтгэл 2013

8 <http://news.gogo.mn/r/159837>

тогтолцооны нэг давхарга болох үндэсний суурь тэтгэврийн даатгалыг нэвтрүүлэхийг санал болгон судалгаа тооцоо хийв. Өндөр настны нийгмийн хамгаалал сайтай улс орнуудад улсын төсөвт учруулах ачааллыг бууруулах, иргэдийн хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор хэрэглэж болох тэтгэврийн хэд хэдэн давхаргууд байдаг байна. Гадаад дотоодын судлаачид, судалгааны байгууллагууд тэтгэврийн тогтолцоог 3-5 давхаргатай байлгах боломжтой гэсэн үр дүнгүүдийг танилцуулсан байдаг. Тухайлбал Швед, Индонез, Америк, Герман, Япон, Хятад, Англи зэрэг улс орнууд нь 2-5 давхаргыг ашигладаг байна.⁹



Дүрслэл 3. Санал болгож буй тэтгэврийн даатгалын тогтолцоо

I давхарга. Үндэсний суурь тэтгэврийн даатгал

Бидний тооцоолж байгаагаар үндэсний суурь тэтгэврийн даатгалын үндсэн нөхцөл нь:

1. Заавал даатгах хэлбэртэй байна.
2. Даатгалд 25-59 насны иргэд хамрагдаж хамгийн багадаа 25 жил шимтгэл төлнө.
3. Даатгалын хураамж иргэн бүрд тэнцүү байх ба хуримтлалыг иргэн өөрөө бий болгоно. Суурь тэтгэврийн даатгалын сангийн орлого нь даатгуулагчийн төлсөн шимтгэлийн орлого болон даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг өсгөж олсон орлогоос бүрдэнэ.
4. Үндэсний суурь тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээ нь дор хаяж тухайн үеийн амьжиргааны баталгаажих доод түвшинтэй тэнцүү байна.
5. Үндэсний суурь тэтгэврийн даатгалыг хэрэгжүүлэгч нь төр эсвэл санхүүгийн байгууллага байж болно.
6. Үндэсний суурь тэтгэврийн даатгалтай холбоотой эрхзүйн орчинг бүрдүүлсэн байна.

II давхарга. Нэрийн дансны тэтгэврийн даатгал

Энэ нь одоогийн мөрдөгдөж байгаа тэтгэврийн нэрийн дансны тогтолцоо, хөдөлмөрийн харилцаанд орсон иргэд бусад давхаргатай зэрэгцүүлэн заавал даатгах хэлбэрээр хэрэв хөдөлмөрийн харилцаанд ороогүй бол сайн дурын хэлбэрээр даатгуулна.

III давхарга. Нэмэлт тэтгэвэр

Энэ нь иргэдийн сайн дурын үндсэн дээр ирээдүйн орлогын эрсдэлийг бууруулах зорилгоор ажил олгогч, эсвэл санхүүгийн байгууллага эрхлэн гүйцэтгэх даатгалын хэлбэр юм. Нэгэнт сайн дурын даатгал учир даатгуулагч өөрөө даатгалын нөхцөлийг гэрээгээр зохицуулан сонгож хэрэглэнэ. Манай улсад энэ төрлийн даатгалын үйл ажиллагааг Нэйшнл даатгал ХХК мэргэжлийн түвшинд эрхэлж байгаа бөгөөд ажил олгогчдоос Голомт банк, МИАТ зэрэг байгууллагууд хэрэгжүүлж байгаа түршлага байна.

Санал болгож буй шинэ давхаргын сан, Санал болгож буй шинэ давхаргын сан, хураамжийн тооцоо (нэг иргэнээр)

Үндэсний суурь тэтгэврийн даатгалд иргэд хамгийн багадаа 25 жилийн хугацаанд шимтгэлээрээ хуримтлал бий болгож 15-16

⁹ Дагвадорж.Ч.(2012).Даатгалын эдийн засаг ба нийгмийн даатгалын тогтолцоо. 110 тал

жил тэтгэвэр авахдаа тэтгэвэрт гарах үеийнхээ амьжиргааны баталгаажих түвшинтэй тэнцүү хэмжээний тэтгэврийг суурь болгон авахаар төсөөлсөн болно. Үүний тулд урт хугацааны даатгалын зарчмаар тодорхой хэмжээний сан бүрдүүлсэн байх шаардлагатай бөгөөд тэр нь дараах томъёогоор илэрхийлэгдэнэ.

$$B_t = \frac{X[(1+r)^{mt}-1]}{r(1+r)^{mt}} = X \frac{[q^{mt}-1]}{q^{mt}(q-1)} \quad (1)$$

B_t – t хугацаанд даатгуулагчийн хуримтлуулах шаардлагатай сангийн хэмжээ

r - Жилийн хүүгийн хэмжээ

X- Тэтгэвэр тогтоох үеийн амьжиргааны баталгаажих түвшин

mt - шимтгэл төлөх хугацаа (сараар)

Эндээс сар тутмын хураамжийн хэмжээг дараах байдлаар тооцно:

$$a = B_t * \frac{r(1+r)^{mt}}{(1+r)^{mt}-1} \quad (2)$$

a – Нэг иргэний нэг удаагийн хураамжийн хэмжээ

Бид 2016 оноос эхлэнэ гэж төсөөлбөл 25-35 насны иргэний хувьд сар бүр төлөх

Хүснэгт 2. Нэг иргэний үндэсний суурь тэтгэврийн санд хуримтлуулах шимтгэлийн орлого

№т	Хувилбар	Хүүний хувь	Даатгуулагчийн шимтгэлээр хуримтлуулах дүн	Шимтгэлийн хэмжээ (мян төг.сар)
1	Цалингийн өсөлт	15.0	53,821.79	124.82
2	Бодлогын хүү	13.0	59,758.82	139.08
3	Хадгаламжийн хүү	15.3	53,014.21	122.88
4	Зээлийн хүү	22.6-27.4	34,889.32	79.5

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Дүгнэлт

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-д хүн бүр нийгмийн хамгаалалд хамрагдах, өөрийн болон гэр бүлийн бусад гишүүний эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хангахад хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй¹⁰ гэж заасны дагуу аливаа улс орны төр засаг өндөр настнуудад амьдрах тааламжтай нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй билээ.
2. Өнөөдөр дэлхий дахинд хүн амын дундаж наслалт нэмэгдэж байгаа нь

шимтгэлийн хэмжээг хэд хэдэн хувилбараар тооцооллоо. Үүний тулд дараах нөхцөлүүдийг тавьсан. 1981 онд төрсөн 2016 онд 35 настай иргэн 2041 онд тэтгэвэр тогтоолгохдоо үндэсний суурь тэтгэврийн сангаас 741000 (бидний экспоненциаль болон ложистик загваруудаар таамагласан 2041 оны амьжиргааны баталгаажих доод түвшин) төгрөгийн тэтгэвэр авахын тулд 25 жил даатгалд хамрагдаж 34,9-59,7 сая төгрөг (хуримтлалд тооцогдох хүүнээс хамаарсан) хуримтлуулах шаардлагатай. Энд хүүг:

- Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн хуулинд заасныг үндэслэл болгон сүүлийн 5 жилийн цалингийн өсөлтийн дундаж хувиар,
- Монгол банкны бодлогын хүүгийн түвшингээр,
- Арилжааны банкуудын урт хугацаат хадгаламжийн хүүний дундаж түвшингээр
- Арилжааны банкуудын урт хугацаат зээлийн хүүний дундажаар тус тус авлаа.

манай улсын хүн амд ч илэрч байна. Үүнтэй холбоотойгоор тэтгэвэр авагчийн тоо өсч, өндөр насны тэтгэвэрт зарцуулах хөрөнгө хомсдож байгаа тул далайцтай, онолын үндэслэл бүхий судалгаа шаардлагатай. Тухайлбал, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75.4 болсон нь байна. Энэ нь 20 жил тэтгэврийн даатгалд шимтгэл төлсөн эмэгтэй 55 настай тэтгэвэр тогтоолгон цаашид 20 жил тэтгэвэр авахаар болсон байна. Тэтгэврийн санд хувь нэмэр оруулах хугацаа, тэтгэвэр авах хугацаатай тэнцүү байсан тохиолдолд төсвөөс санхүүжилт зайлшгүй шаардлагатай болно. Үүнээс гадна

¹⁰ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1946-12-10 өдөр “Хүний эрхийн түгээмэл тунхаглал” 23-р зүйл 3

20 жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн иргэнд дундаж цалингийнх нь 45 хувиар л тэтгэвэр тогтоогдоно. Энэ нь амьжиргааны баталгаа болох боломжгүй болно.

3. Улс орон бүрийн хөгжлийн төлөв хандлага, өвөрмөц байдал, эдийн засгийн чадавхи, хүн ам зүйн хөгжил, хөдөлгөөн нь өндөр насны тэтгэврийн тогтолцоог байнга шинэчилж байхыг шаардаж байна. Манай улсад үүсч байгаа эдийн засаг нийгмийн өөрчлөлт шинэчлэлтийн нөлөөгөөр иргэдийн амьжиргааны өртөг өсч түвшин доошлох, төгрөгийн худалдан авах чадвар алдагдах, тэтгэврийн насны иргэдийн тэтгэврийн орлогын хэмжээ тэдний амьжиргааг хангаж чадахгүй болох, тэтгэврийн сан зарлагаа нөхөж дийлэхгүй байх зэрэг сөрөг үр дагаваруудыг дагуулсан нь нийгэмд тааламжгүй уур амьсгалыг бий болгож байна.
4. Өндөр насны тэтгэврийн даатгалын тулгамдсан асуудлуудыг түр зуурын аргацаасан арга хэлбэрээр зохицуулах замаар шийдэж ирсэн нь энэ салбарын хувьд шийдвэрлэвэл зохих олон асуудал хуримтлагдан томоохон эрсдэл дагуулсан явдал болсон. Бидний санал болгож буй тэтгэврийн даатгалын шинэ давхаргыг заавал даатгалын хэлбэрээр хэрэгжүүлбэл

иргэд өндөр насны тэтгэвэрт гарахдаа амьжиргааны баталгааг хангах түвшиний орлоготой болох бөгөөд иргэн зөвхөн энэ давхаргаар 741.0 мянган (тухайн үеийн амьжиргааны баталгаажих түвшин) төгрөгийн суурь тэтгэвэр авахын тулд хүүний түвшингээс хамааран сар бүр 79,5-142.0 мянган төгрөгийн шимтгэл төлж 34,9-59,7 сая төгрөгийн санг хуримтлалаараа бий болгох юм.

Ашигласан материал

1. Дагвадорж.Ч. “Даатгалын эдийн засаг ба нийгмийн даатгалын тогтолцоо”. 2012 он УБ.
2. Л.Алтангэрэл, Б.Болормаа “Санхүүгийн математик” УБ 2009 он
3. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1946-12-10 өдөр “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”
4. “Тэтгэврийн бодлогын шинэчлэлийн хувилбарууд” судалгааны тайлан 2012 он. Дэлхийн банк
5. Статистикийн эмхэтгэл 2014. Үндэсний статистикийн хороо
6. Нийгмийн даатгалын статистикийн эмхэтгэл, 2014
7. <http://economy.news.mn/content/187560.shtml>
8. <http://www.polit.mn/content/59073.htm>
9. <http://news.gogo.mn/r/159837>